

Шинэхээн буриадын төр хуримын сэргэ босгох ёсноос Чингис хааны намрын тахилгын нэрийдлийг зүйчлэх нь

Толон ^{1,*}

Товч агуулга: Буриад аялгаар морь уях шон болон уяан зэлийг “сэргэ” гэж нэрлэдэг. Өвөр Монголын Хөлөнбуйрын Шинэхээн буриадууд уг гарвалаа “хун шувуун гарвал, хусан модон сэргэтэй” гэж домоглон хун шувууг тотем шүтээнээр дээдлэж, хусан модон сэргийг уг гарвалын сүлд тэмдэг болгон үзэж, хүүгээ гэрлэж төр хурим хийхэд хус модон сэргэ босгодог заншилтай. Энэ нь нэг талаар харь холоос хүүхэн үрээн хүргэж ирсэн худ ургууддаа бэлтгэсэн уяан зэл болохоор барахгүй, нөгөө талаар энэ буриад айл хүүгээ гэрлүүлж, уг үндсээ залгамжлан гал голомтоо бадраасныг тунхаглаж байгаа сүлд тэмдгийн үүрэг зориулалттай байна. Тус өгүүлэлд Шинэхээн буриадын хус модон сэргэ босгох ёс заншлыг Чингис хааны дөрвөн цагийн тахилга дахь намрын улирлын хуримтай холбон үзэж, эрдэмтдийн урьдах судалгааныг эшлэн задлаад, энэхүү эрхэм их төрийн ёслолын нэрийдэл нь “ногт шөргийн хурим” биш, харин “ногт сэргийн хурим” болно хэмээн зүйчлэн гаргасан байна.

Түлхүүр үг: Шинэхээн буриад, сэргэ босгох, Чингис хааны намрын тахилга

Удиртгал

Археологийн судалгаагаар нүүдэлчин угсаатны дунд хүрлийн үеэс улбаатай уламжлагдсаар ирсэн “сэргэ босгох” зан үйл, жич “сэргэ” гэх эртний монгол үг нь олонх монгол угсаатанд орхигдон мартагдсан ч Шинэхээн буриадад одоо хүртэл идэвхтэй хэрэглэгдэж, соёлын утга, зан үйлийн бэлгэдэл, нийгмийн үүрэг чадамжаа бүрэн бүтэн хадгалсаар иржээ. Шинэхээн буриадын хус модон сэргэ босгодог ёс заншлаас баримт авч, Чингис хааны дөрвөн цагийн тахилга дахь намрын улирлын хуримын нэрийдлийг нарийвчилж үзвэл, энэхүү эрхэм их төрийн ёслолын нэрийдэл нь “ногт шөргийн хурим” биш, харин “ногт сэргийн хурим” гэх нь зүйтэй гэж үзнэ.

Хөлөн буйрын Шинэхээн буриадууд төр хуримын ёслолыг гэрийн гадна тэгшхэн газар өмнө талаараа задгай дүгрэг суудал засаад олон бүгдээр монгол гэрт суух ёсыг чанд баримтлан, эрчүүд баруун талаар, эмэгтэйчүүд зүүн талаар, ёс насны эрэмбэ дараагаар дугуйран суудаг уламжлалтай. Буриадууд ийм хуримыг “дүхэригэй төр” гэж, ингэж суудал засахыг “төрийн дүхэриг засах” гэнэ. Төрийн дүхэригийнхээ өмнө, эсвэл баруун өмнө зүгт нь хоёроос гурван хусан модон багана босгож, сураар зэл татаад, “сэргэ” гэж нэрлэнэ. Энэхүү сэргэ нь дараах үүрэг зориулалттай.

Нэгд, Шинэхээн буриадууд “хун шувуун гарвал, хусан модон сэргэтэй” гэж домоглодог учраас хун шувуу, хусан модон сэргийг уг гарвалын сүлд тэмдэг гэж үзнэ. Тотем шүтлэг бол ямар нэгэн ургамал,

амьтан бодсыг өөрийн овог аймгийн тотем болгон дээдэлж, тотемтойгоо удам гарлын холбоотой гэж үздэг. Тотем шүтлэг нь тотемын домог, тотемын хувилгаан, тотемын төв, тотемын ёслол болон цээр зэргээс бүрддэг (Оч 210: 276). Хун шувуун тотемын домог, хун шувуун гарвалтай, хусан модон сэргэтэй гэх тотемын хувилгааны бэлгэдэл, хорь буриадын уг нутгаар тотемын төв болгож, хун шувууг ирэх буцах цагт сүүн цацал өргөн дээдлэх, хус модон сэргэ босгож уг гарвалаа тодотгох нь тотемын ёслол, хун шувууг хөнөөж хорлож болохгүй гэсэн тотемын цээр зэргээс хун шувуу, хус мод нь Хори буриадын тотем шүтлэг байх бүх нөхцөл элементийг бүрэн болгож байна. Тотемын шүтлэг нь овог аймгийн хамт нийтийн чанартай үзэгдэл болох юм. Тэр нь нэг талаар овог төрлийнхөө дотоодын эв нэгдлийг бэхжүүлж, нөгөө талаар өөр тотемтой овог төрлийнхнөөс ялгаж, улмаар овгийн гаднах ургийн байгууламжийн бүрэлдэх суурь болжээ. Юмсэнгийн Вандан буриад бөөгийн чанар нэрэх зан үйлийн тухай өгүүлэхдээ “Гишүү навч мөчир төгс, хоёр бүдүүн хусан модыг авчран зоож, өмнөхийг нь эцэг мод хэмээгээд түүний оройд нарны дүрс бүхий үйсэн дээр улаан хоргой торго нааж уяад нар хэмээн нэрлэнэ. Арынхыг нь эх модон хэмээгээд оройд нь шувууны үүрийг торгон бус эдийн үртсээр хийгээд түүний дотор хөвөн буюу хонины ноосоор есөн өндөг хийж, сарны дүрс бүхий дүгрэг ноосон дээр цагаан хоргой торго нааж уяад сар хэмээн нэрлэнэ. Мөн гишүү навч мөчир төгс, гурван ес хорин долоон жигд сайхан хус модыг элдэв ангийн арьс, өнгө бүрийн бөсийн үртэс уяж чимэглэнэ. Эдгээр бүгдийг эх цагаан чанар хэмээн нэрлэнэ” (Насан-Өлзий нар, 1999: 86) гэснээс үзэхэд, гишүү навч мөчир төгс хус

¹ БНХАУ, ӨМӨЗО, Хөлөнбуйр дээд сургууль

* Холбоо барих зохиогч: 2015901828@qq.com

мод нь хорь буриадын дээдсийн тахилга буюу уг хүндлэх зан үйлд, наран, саран, эцэг эхийн бэлгэдлээр илэрч, удам угсаа бадран дэлгэрэх өлзий дэмбэрлийг харуулж байна. Иймээс төр хурим хийхэд хус модон сэргэ босгодог нь энэ буриад айлын хүү нь гэрлэж уг үндсээ залгамжлан гал голомтоо бадраасныг тунхаглаж байгаа сүлд тэмдгийн үүрэг зориулалттай байна. Үүнийг Чингис хаан эсгий туургат улсыг шударгуудхаж, барс жил Ононы тэргүүнээ хурж, есөн хөлт цагаан тугийг байгуулаад Чингис ханаа хаан нэр өгч, нэгдсэн Монголын хаант төрийг тунхагласантай холбож бодвол, мөн төрт ёсны соёлын илрэл гэж үзэж болно.

Хоёрт, Шинэхээн буриадууд хүний сайныг гэртээ цуглуулж, хүлгийн сайхныг гаднаа уяулах өлзий дэмбэрлээр, охиноо хүргэж ирсэн эрхэм хүндэт худ ургуудынхаа хүлэг морины жолоог тосон авч хусан модон сэргэдээ буулгадаг. Мөн ахмад настан нь шинэ хуримласан гэр бүлд “Хусан модон сэргийг тань хүлгийн жолоо элээж байг, хүрэн зандан босгыг тань хүүхдийн хөл элээж байг, сэргээс тань зон бүү тасраг, сүргээс тань чоно холдог” гэх зэргээр адуу мал, үр хүүхдээр өнөр өтгөн, элбэг баян, айлчин гийчин тасралгүй, найр цэнгэл баяр баясгалангаар дүүрэн байхыг бэлгэдэн өлзийтэй сайхнаар ерөөл тавьдаг. Иймээс төр хуримдаа хусан сэргэ босгох нь худ ургууддаа бэлтгэсэн уяа эзлээс гадна баян тансаг баяр жаргалыг бэлгэдэх зориулалттай байна. Үүнийг Чингис хааны дөрвөн цагийн хуримын “Ногт элний хурим”-тай холбож үзвэл, хусан модон сэргэ босгох нь монгол төрт ёсны илрэл болох нь тодорч байна. Хубилай сэцэн хааны шашин төр хоёр ёсныг тэгш явуулах хууль цааз, дүрэм тогтоол болох “Арван буянт номын цагаан түүх”-д “Чингис хааныг дурсах онгон тахилга болгож дөрвөн цагийн хуримыг үйлдсүгэй хэмээж, хаврын эцэс өөлжин луу сарын хорин нэгнээ Чингис хаан 99 гүүгээ уяж, цагаан сацлаа сацсанаар хаврын цагаан сүргийн хуримыг эл өдөр үйлдэх, зуны дундад морин сарын 16-нд ертөнцийн шүтээн дэлгэр эх тунагийг тавьж, 99 цагаагчдын уураг үрсийг гаргаснаар зуны нуурын хуримыг тэр өдөр үйлдэх, намрын эцэс нохой сарын 12-нд унаганы чагт шилбийг эвхсэнээр ногт сэргийн хуримыг тэр өдөр үйлдэх, өвлийн дундад хулгана сарын гунан шинэд Чингис хааны милаагуудыг хийснээр өвлийн тасам тавихуйн хуримыг тэр өдөр үйлдэх” (Лю Жин Сүө 200: 89-90)” гэж тогтоосноос хойш одоо болтол Чингисийн онгонд уламжлан энэ хэвээр тахисаар ирсэн байна.

Энэхүү дөрвөн цагийн тахилга дахь намрын улирлын ногт сэргийн хуримын нэрийдлийг тулгуур бичгүүдэд адил бусаар тэмдэглэсэн нь харагдана. “Арван буянт номын цагаан түүх”-д “ногт сэргийн хурим” гэж, “Чингис хааны алтан бичиг дэх эл бичгүүдэд “ногт сэргэ эвхэх найр, сэргийн хурим,

шөргийн хурим гэх мэт адил бишээр тэмдэглэж, “Эрдэнийн эрих”-д “намрын улирлын сэргийн хурим”, Богд Чингис хааны тахилын сударт “Намрын шөргийн тахил” гэж, “Алтан ордны дайллага”-д “Намрын шөргийн дайллага” гэж тус тус гардаг. Энэ тухай судалсан эрдэмтдийн саналыг хураангуйлбал, **нэгд,** На.Хурцбилиг “шөргэ” гэх нь зүйтэй гэж үзсэн. Тэрбээр “Хорин нэгт тайлбар толь” дахь “Моголцог модон дор хэд хэдэн унийг солбиулан хэлхэн хийж, халхлах, хаахыг шөргэ хэмээмөй” гэх тайлбар ба “Монгол хэлний толь” дахь “Эхээ дагаж бүхий тугал бярууг хөхүүлэхгүйн тул хамарт нь барьж уядаг сэрэвгэр шор буюу дөрвөн мод солбицуулан хийсэн хэрэгсэл, хөхөх гэхэд эхийгээ хатгах тул эх нь хөхүүлэхгүй зайлаад байх болно” гэх тайлбарт тулгуурлаж, “МНТ-д дахь Хэрэйдийн Ван хаан таван ямаа шөргөлөн сааж..” гэснийг иш татан, тэр үед унага тугалд зүүхээс гадна ишиг хурганд хүртэл шөрөг зүүлгэдэг байжээ. Шөрөг зүүлгэх арга туршлагын давуу тал нь төлийг нь шөргөлөөд эхтэй нь хамт хариулахад төл нь эхээ дагаж явах болохоор хэзээ хаана чухал үед гүүгээ сааж болох явдал болно гэж үзжээ (Хурцбилиг 2009: 73-76).

Хоёрт, Сайнжаргалаас, “Монголчууд унаганд язгуураасаа шөрөг гэх хэрэгслийг огт хэрэглэсэнгүй учир “унаганы шөргийг авч” гэсэн нь үнэн байдалтай зохицохгүй юм. Сурвалж бичгийн тэмдэглэлээс нарийвчилбал, “сэргийн хурим” хэмээн нэрийдэх нь зөв болох нь лавтай гэж үзээд, “Чингис хааны тахилын судар” гэдэг номд “цагаан сүрэг гүүг ордны дэргэд барих гэснийг “хүн барьж зогсоно” хэмээн инээдтэй тайлбар зүүлгэснийг буруушааж, цагаан сүрэгт олон гүү байдаг тул үүнийг нэг нэг хүн барьж зогсоно гэвэл чухам яршигтай хачин хэрэг болох юм. Ном дахь үгийн утга нь “ордны дэргэд гүүн зэлээ татах гэсэн үг” гэж тодорхойлсон байна (Сайнжаргал 2001: 244).

Гуравт, Т.Эрдэнэтогтох нар На.Хурцбилигийн үзсэнийг зөвшөөрч, “шөргийн дайллага” гэж нэрийдэв. Тэрээр ордос нутгийн аялгад шөрөг, шөрх шөрөө гэж дууддаг. Гэтэл одоогийн эзэн захын дархад нар эдгээрийн алинаар нь ч хэлэхгүй, шөрөг гэж хэлдэг байна. Энэ нь даруй шөргөөх гэдэг үгийн үндэс шөрөг болно гэжээ (Эрдэнэтогтох 2017: 83).

Буриад аялгаар морь уях шон болон уяан зэлийг сэргэ гэж нэрлэдэг тул гүү, унагадын ногт чагтыг мулталж, бат зэлээ эвхэж хураасан энэ хуримын нэрийдлийг “**ногт, сэргийн хурим**” гэж нэрлэх нь зайлшгүй зүйтэй гэж үзнэ. Учир нь гэвэл, Чингис хааны намрын улирлын ногт сэргийн хурим бол намрын сүүл сарын 12-нд, 99 цагаагч гүүний исэгээр Бадрангуй цагаан тэнгэр, богд эзэн Чингис хаандаа дархан тахил, далай сахилаа өргөж, дэлгэрэнгүй их дайллага талбиад, буман сүргийн бэлгэдэл болсон бат зэлээ эвхэн хурааж, цэгээний гүү унагадын сэргэ, ногтыг

суллаж тавьсныг тэмдэглэсэн төрийн их ёслол болно. Ерөөсөө аливаа үйл мөрт өлзий бэлгийг эрхэмлэдэг монголчууд ийм эрхэм хүндтэй төрийн их ёслолд эх төлийг хатгаж салгах зорилготой шор шөргийг бэлгэшээх ёсон огт байж болшгүй юм. Шөрөг гэгч нь тугал ботгонд хэрэглэдэг болохоос, монголчуудад унага шөрөглөх зуршил огтоос байсангүй. Харин өнөр сүргийн үржиж өсөхийг бэлгэшээн урт сайхан зэл сэргэ татаж, эх төлийг нийлүүлэн сүү сааль авах, хол ойрын айлчин зочдыг угтаж буулгадаг уяа зэл сэргэ татаж, харь халууныг нэгдүүлэн найрлан хуримлахад зэл сэргийг эрхэмлэн үзэх ёс заншил эртнээс улбаатай юм. Иймээс ногт шөргийн дайллага биш, харин зэл сэргэд эх төлийг нийлүүлэн үржүүлж, айлчин зочныг угтан буулгадаг “ногт сэргийн хурим” гэх нь үнэн зөвд нэн ойр болно. Энэ “ногт сэргэ” гэх үг нь анхан “Арван буянт номын цагаан түүх”-д тэмдэглэгдсэнээс хойш олон зууны турш хуулбарлан дамжуулах явцад эртний (эм хүйс) ялгаа зөрөөнөөс болж “сэргэ, ширүгэ, ширгү, ширэгэ, сүргэ, ширэ” гэх мэтээр хэлэгдэн бичигдэж ирсэн байна. Тус хуримын тахилгын судар болсон “Бат зэлийн ерөөл”-д эзэн тэнгэртээ сацал өргөн, эр эм хүйсний бэлгэдэл, үржиж өсөхийн бэлгэдлээр зэл сэргийн бат мөнх, зон ардын баяр жаргалыг хүсэн даатгадаг. Тухайлбал:

*“Бадрангүй цагаан тэнгэртээ сацлаа өргөн,
Хугарашгүй мөнх гадас (эр хүйс),
Тасаршгүй мяндсан бат зэлээ татаж (эм хүйс)
Өргөн далайн хүйс болсон
Этүгэн эхийн хөвч болсон эзлэндээ (эм хүйс)
Зээрд хулан мэт олон болсон ногтотын чинь,
Нугасан халиун (галуун) мэт олон болсон эр унага чину
Мянган агтын манлай болтугай! (эр хүйс),
Охин унага чину түмэн адууны эх болтугай! (эм хүйс, үржил төлжил)
Хунианаас сүүтэй болтугай, (эм хүйс, үржил төлжил)
Хусрангаас хээлтэй болтугай... (эм хүйс, үржил төлжил)
Бат зэлийн (эм хүйс) мөнх гадсаа (эр хүйс) татаад,
Дархан тахил далай сахилаа өргөхөөр ...
Зүлэгт голын эхэнд бууж, зээрд цоогчин гүүгээ
ногтлоод, (эм хүйс)
Зүрчидийн Чуу мэргэнээр зэлээ татуулж,
Ойрадын Хар Хиругэгээр унагаа татуулж,
Хамаг бүгд даяараа хаан мөнх тэнгэрт сацлаа өргөж,
Эгээрсэн эгээрсэж, баярласан баясаж,
Эгээ л хутаг хүслэн жаргалангийн дунд мөнх болтугай!
Умай дэлгэрч унаган гарч (эм хүйс, үржил төлжил)
Уураг дэлгэрч сүүн гарав (эм хүйс, үржил төлжил) ...
Аман дур амсалгүй, алган дур дусаалгүй
Бат зэлийн (эм хүйс) мөнх гадасдаа (эр хүйс)
Бадрангүй сацал өргөнөм.
Эгээрсэн эгээрсэж, баярласан баясаж,
Эгээ л хутаг хүслэн жаргалангийн дунд мөнх болтугай! ...
Худаг усанд бүү эндтүгэй! Хулгай дээрэмд бүү*

авттугай!

Хижиг гэмд бүү өрттүгэй! Хурц соёотонд бүү учиртугай!

Хувилж унасан эзэн чину мөнх болтугай!” хэмээн ерөөдөг (Эрдэнэболд нар, 2016: 49-52).

Үүнийг Хори буриадын “Хун шувуун гарвалтай, хусан модон сэргэтэй” гэх домог дуудлага ба буриад бөөгийн уг хүндэлж, чанар нэрэх зан үйл дэх эцэг наран мод, эх саран модтой нөхцөлдүүлэн холбож үзвэл, шинэхээн буриадын төр хуримд хусан модон сэргэ босгоод, эр эм нийлж айл гэр болох, харь халуун нийлж төр бүтэх төрт ёсны дэмбэрэл бэлгэдэл гүйцэд харагдаж байна. Дахивал “Бат зэлийн ерөөл”-ийн бүх агуулгаас үзэхэд бат зэл мөнх гадас гэдэг нь “сэргэ”-ийг зааж байгаа болвоч “сэргэ” гэх үг ерөөс илэрсэнгүй. Энэ нь Чингис хааны дөрвөн цагийн тахилгыг эрхэлж байсан Монголын төв орон дахь монголчуудын дунд “сэргэ” гэх үг нь нэгэнт орхигдон мартагдсаны улмаар намрын улирлын хуримын нэрийдэл нь төөрөгдөж, дээрх мэт элдэв нэрийдэлтэй болсоныг харуулж байна.

Эрдэмтэн Модонгууд Ц.Төрбат “Сэргэ-эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент” (2000) гэх өгүүлэлдээ “Хүрлийн үеэс булш оршуулганд “сэргэ” босгох зан үйл уламжлагдсаар Хүннү, Түрэг, Монголын үед ирэхдээ монгол-түрэг ард түмнүүдэд аль алинд нь хэрэглэгдэж байжээ. Гэвч бүхний мэдэхээр түрэг, уйгурчуудад морийг эзэнтэй нь хамт булшлан оршуулах ёс давамгайлж байсан билээ. Харин монголчуудын хувьд түүний дотор дундад зууны монголчуудын хувьд хойлго морийг булшин дээр босгосон “сэргэ”-д уяад хээрийн амьтанд өгөх буюу зүлдлэн өвчөөд “сэргэ”-д хатгадаг заншил ноёлж байсан бололтой” (Төрбат 2000)” хэмээн тэмдэглэсэн нь “сэргэ босгох” нь нүүдэлчдийн угсаатны дундах нэн эртнээс уламжлалтай зан үйл болохыг тодруулсан байна. Одоо болоход, энэ “сэргэ” гэсэн эртний монгол үг нь олонх монгол угсаатанд мартагдан төөрөгдсөн ч Шинэхээн буриадад одоо хүртэл идэвхтэй хэрэглэгдэж, соёлын утга, зан үйлийн бэлгэдэл, нийгмийн үүрэг чадамжаа бүрэн хадгалсаар байгаа юм.

“Нутгийн аялгуу нь нэгдмэл хэлний салбар ба хувилбар болохоор үл барам мөн ч нэгдмэл хэлний бүрэлдэн төлөвшрөхийн хөрс шороо ба баялагжин төгөлдөржихийн эх баялаг мөн (Мандах 2006: 97) гэсэнчлэн Шинэхээн буриадад хэл аялгуун дахь “сэргэ” гэх үг ба хусан модон сэргэ босгох ёс заншил нь эдүгээд хүртэл хадагалагдан ирэхдээ уугал монгол хэл соёлын утга бэлгэдлийн оньсыг учирлан тайлбарлах алтан түлхүүр бүхий өв соёлын үнэт хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй. Энэ бүхнээс дүгнэж үзвэл:

1. Хүрлийн үеэс булш оршуулганд “сэргэ” босгох зан үйл уламжлагдсаар Хүннү, Түрэг, Монголын үед

ирэхдээ монгол-түрэг ард түмнүүдэд аль алинд нь хэрэглэгдэж байжээ.

2. Шинэхээн буриадууд уг гарвалаа “хун шувуун гарвал, хусан модон сэргэтэй” гэж домоглон хун шувууг тотем шүтээнээр дэдлэж, хусан модон сэргийг уг гарвалын сүлд тэмдэг болгон үзэж, хүүгээ гэрлэж төр хурим хийхэд хус модон сэргэ босгодог заншилтай.

3. Сэргэ бол уяан шон бую уяан зэл мөн. Чингис хааны намрын улирлын ногт сэргийн хурим бол 99 цагаагч гүүний исэгээр Бадрангуй цагаан тэнгэр, богд эзэн Чингис хаандаа дархан тахил, далай сахилаа өргөж, дэлгэрэнгүй их дайллага талбиад, буман сүргийн бэлгэдэл болсон бат зэлээ эвхэн хурааж, цэгээний гүү унагадын сэргэ, ногтыг суллаж тавьсныг тэмдэглэсэн төрийн их ёслол болно. Иймээс энэхүү эрхэм их төрийн ёслолын нэрийдэл нь эх төлийг хатгаж салгах зорилготой шор шөргий хурим биш, харин зэл сэргэд эх төлийг нийлүүлэн үржүүлж, айлчин зочныг угтан буулгадаг “ногт сэргийн хурим” гэх нь үнэн зөвд нэн ойр болно.

Тус өгүүлэл нь ӨМӨЗО-ны их дээд сургуулийн Хүмүүнлэг нийгмийн ухааны голдолгот судалгааны суурин газар - Хөлөнбуйрын үндэстний түүх соёлын харилцаа солилцоо уусалцлын судалгааны суурин газрын үр бүтээл болох “Биет бус соёлын өвийн хамгаалалтын хараан дахь Хөлөнбуйрын буриад монголчуудын төр хуримын соёлыг уламжлан дэлгэрүүлэх судалгаа” төслийн өгүүлэл болно.

Abstract

From the “Serge bosgoqu” ritual of the Shinekheen buriyad wedding the identity of Chinggis khan’s autumn patch

Tao Long

The article mentions the ritual of “Serge bosgoqu” (putting up hitching post) that has been handed down from the Bronze Age among the nomadic tribes. The ancient Mongolian word “serge” has been abandoned and forgotten by many Mongolian tribes, but it is still actively used in Shinekheen buriyad and has cultural meaning, ritual symbols, and social roles. Based on this, it is concluded that the Autumn Feast, as one of the Chinggis Khan’s four-season ritual, is “Nogt sergiin khurim”, where people put up a hitching post that unites mares and foals, rather than “Nogt shurgiin khurim” to separates mares and foals with the fork.

Keywords: Shinekheen buriyad, Serge bosgoqu, Chinggis khan’s autumn patch

Ном зүй

Лю Жин Сүө (2000). Арван буянт номын цагаан түүх. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, Хөх хот.

Мандах (2006). Монгол хэлний заншлын судлал. Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин.

Насан-Өлзий, Билиг нар (1999). Буриадын түүхэн сурвалж бичиг. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, Хайлаар.

Оч (2010). Монгол зан үйл. Эрхлэн найруулсан Оч. Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо, Хөх хот.

Сайнжаргал (2001). Монгол тахилга. Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин.

Төрбат, Ц. (2000). Сэргэ-эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент: In: “Studia Ethnologica Instituti Historiae Academiae Scientiarum Mongoli”. Tom. XII, Fasc. 14, Улаанбаатар.

Хурцбилиг, На. (2009). Чингисийн тайлгын соёл судлал. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөх хот.

Эрдэнэболд нар. (2016). Чингис хааны алтан бичиг. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, Хайлаар.

Эрдэнэтогтох, Г. (2017). Чингисийн онгоны тайлгын ёслол журам, жич соёлын чадавхийн судлал. Ляонингийн үндэсний хэвлэлийн хороо, Чанчун.

Received: Oct. 16, 2024; Revised: Nov. 23, 2024; Accepted: Dec. 16, 2024

